

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-12
<hr/>	
<i>1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Дэд хорооны даргыг сонгох тухай/</i>	3-5
<i>2.Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын талаар</i>	5-12

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 20-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 46 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: С.Эрдэнэболд, Р.Эрдэнэбүрэн;
Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Б.Батбаатар, Д.Ганбат, Ц.Мөнхбат, Л.Оюун-Эрдэнэ, Б.Тулга, Х.Тэмүүжин, Д.Цогтбаатар, Ө.Шижир, Л.Энхнасан.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Дэд хорооны даргыг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Б.Гандиймаа, А.Наранцэцэг нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал Тусгай хяналтын дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэгийг нэр дэвшүүлэв.

Нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр, Ж.Энхбаяр нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Тусгай хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэгийг сонгох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	5
Бүгд:	16

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тусгай хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэгийг сонгохыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоол баталсанд тооцов.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн “Дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолыг танилцуулав.

Уг асуудлыг 12 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын талаар

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Б.Гандиймаа, А.Наранцэцэг нар байлцав.

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр, Д.Бум-Очир нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцав.

Уг асуудлыг 13 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 31 минут үргэлжилж, ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр 13 цаг 17 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
12 цаг 46 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Лувсанямын Гантөмөр гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Сүрэнжавын Лүндэг гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирснээр 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны ирц бүрдсэн байна. Ингээд энэ өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудал 2 асуудал байгаа. 1 дүгээр асуудал Дэд хорооны даргыг сонгох тухай асуудал байна. 2 дугаар асуудал Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн мэдээллийг сонсохоор байгаад байгаа. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Дэд хорооны даргыг сонгох тухай/

Хэлэлцэх асуудал 1 дүгээр асуудал Дэд хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж эхэлье. Дэд хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлыг Монгол Ардын намын бүлгийн дарга Батжаргал дарга, олонхын бүлгийн дарга танилцуулна. Батжаргал даргыг микрофонд барьж байна.

Ж.Батжаргал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны хурлын ирцийн цагийг яг нарийн мэдээгүй жоохон хүлээлгэчих лээ, уучлаарай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны харьяа Тусгай хяналтын дэд хорооны даргад Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэгийн нэрийг дэвшүүлж байна.

Сүрэнжавын Лүндэг 1982 онд Улаанбаатар хотод төрсөн. Ам бүл 6, эхнэр 4 хүүхдийн хамт амьдардаг. 1999 онд нийслэлийн ерөнхий боловсролын 52 дугаар сургууль, 2004 онд Шинжлэх ухаан, технологийн их сургууль Компьютер, техник менежментийн сургуулийг, 2013 онд АНУ-ын Страйерийн их сургуулийг магистр, 2014 онд Япон улсын Саппорогийн олон улсын их сургуульд төрийн удирдлагын магистр, 2024 онд Монгол Улсын их сургууль Улс төр судлал, олон улсын харилцаа,

нийтийн удирдлагын сургууль Улс төр судлалын магистрын зэрэг тус тус хамгаалсан.

2006-аас 2009 онд Монгол Улсын Их Хурлын гишүүний туслах, 2010-аас 11 онд МАН-ын ажлын албанд, 2014-өөс 2017 онд Монгол Улсын Шадар сайдын туслах, 2017-гоос 2019 онд Монгол Улсын Ерөнхий сайдын шадар туслах, 2020-оос 21 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, 2021-ээс 2024 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх, 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Улсын Их Хурал, Засгийн газарт ажилласан байдал, мэдлэг, чадвар, туршлагыг нь харгалзан Сүрэнжавын Лүндэгийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны харьяа Тусгай хяналтын дэд хорооны даргад нэрийг нь дэвшүүлж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Батжаргал даргад баярлалаа. Дэд хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлаар өөр саналтай гишүүд байна уу? Алга байна, байхгүй байна. Дэд хорооны даргад нэр дэвшүүлж дууслаа. Дэд хорооны даргад нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүд байна уу? Гантөмөр гишүүнээр тасаллаа. Гантөмөр гишүүн үг хэлнэ.

Л.Гантөмөр: Лүндэг гишүүнд амжилт хүсье. Ер нь парламентын уламжлал энэ Тусгай хяналтын дэд хороог парламентад нэлээн удаан суучихсан, тэгээд парламентынхаа үйл хэргийг сайн мэддэг, дээр нь парламентын гишүүний хувьд бүрэн бэлтгэгдсэн ийм хүмүүс ахалж явсан ийм уламжлал байдаг гэж би хувьдаа анзаардаг юм. Тэгээд Лүндэг гишүүний хувьд анх удаагаа сонгогдсон залуу хүн. Яагаад гэвэл энэ хууль хяналтын байгууллагын тусгай ажиллагааны тухай зүйлсийг ярьдаг ийм дэд хороо. Өөрөө хууль хяналтын байгууллагуудын атгад ерөөсөө орж болохгүй. Хууль хяналтын байгууллагуудыг удирддаг тэр удирдагчдын чиглэлд автаж болохгүй. Ийм л их хариуцлагатай дэд хороог Лүндэг гишүүн ахлах гэж байна, явдал суудлаа сайн хардаг болох хэрэгтэй. Өөрийн эргэн тойронд байгаа хүмүүс чинь энд тэнд бизнес хийж байх бий, тэрийгээ анхаардаг болох хэрэгтэй. Гадуур, дотуур архи дарс хүртдэг ажлыг таслан зогсоох хэрэгтэй.

Ер нь энэ Тусгай хяналтын хорооны үйл ажиллагаа өөрөө их цэгцтэй номтой байвал хууль хяналтын байгууллагууд үйл ажиллагаагаа цэгцэлж зөв болох. Ордон дотор битүү тийм яриа байгаа шүү дээ. Хүмүүсийн нэрийг дохио зангаагаар хэлдэг, утсаараа ярьж чадахаа больчихсон, хуурамч дугаар ашигладаг, Монголын томчуудаас айдаг, сүрддэг, бүгдэд нь таних тэмдэг өгчихсөн, өрөөндөө юм ярьж чадахаа больчихсон, замбараагүй байдал байгаа шүү. Эсрэгээрээ Тусгай хяналтын дэд хороо бүх юм хууль дүрмийн дагуу байгаа гэдэг ийм итгэлийг Монгол Улсын Их Хуралд өгч байх ёстой, бүх юм хууль дүрмийн дагуу байгаа шүү гэдэг тэр итгэл үнэмшлийг Засгийн газартаа өгч байх хэрэгтэй. Тийм учраас Лүндэг гишүүн илүү хариуцлагатай, Ерөнхий сайдын туслах, зөвлөх хийж байсан хүн байна, Их Хурлын гишүүний туслах, зөвлөх хийж байсан хүн байна, тэндээс сурч мэдсэн зүйлс нь энэ туршлагад нь хүрнэ гэж Батжаргал дарга үзээд дэвшүүлж байгаа юм байна гэж ойлгож байна. Тэгээд ажилд нь амжилт хүсье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Гантөмөр гишүүнд баярлалаа. Энхбаяр сайд үг хэлнэ, Ж.Энхбаяр.

Ж.Энхбаяр: Лүндэг гишүүн Монгол Улсын Ерөнхийлөгчийн ахлах зөвлөхөөр нэлээн удаан ажилласан, нарийн ширийн юмны нэлээн зах зухыг нэлээн сайн

гадарлаж ойлгож байгаа. Тэгээд энд үг хэлэх илүүдэхгүй, анхааруулга өгөхөд. Гадна, дотнын бүх тусгай албаны хяналтад орно шүү. Явдал суудлаа хянах, сая Гантөмөр гишүүн маш үнэтэй зөвлөгөө өглөө. Монгол Улсын онц чухал, маш нууц бүх төсөл, хөтөлбөр энэ Тусгай хяналтын хороогоор дамжиж байгаа. Тэгэхээр та маш хариуцлагатай, өөрөө өөртөө, үнэхээр эргэн тойрондоо маш сайн дүгнэлт хийж, явдал суудлаа цэгнэж ажиллаарай гэдгийг л хүсье.

Г.Тэмүүлэн: Үг хэлсэн гишүүдэд баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалтыг явуулж эхэлье. Тусгай хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжав овогтой Лүндэгийг сонгох саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт явуулъя. 16 гишүүнээс 11 гишүүн зөвшөөрч, 68,8 хувиар дэмжигдлээ. Энхтүвшин гишүүний төхөөрөмж ажиллаагүй байна. Энхтүвшин гишүүнийг дэмжсэнээр авъя. 12 гишүүн дэмжсэн байна. Байнгын хороодын гишүүдийн олонхын саналаар Тусгай хяналтын дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэг ингээд сонгогдлоо. Та бүхэнд тусгай хяналтын дэд хорооны дарга сонгогдсоноор Байнгын хорооны тогтоол батлагдсанд тооцдог. Та бүхэнд байнгын хорооны тогтоолыг уншиж танилцуулъя.

Дэд хорооны даргыг сонгох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10, 27.11 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсгийг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэгийг Тусгай хяналтын дэд хорооны даргаар сонгосугай. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн байна. Байнгын хорооны тогтоол батлагдлаа. Лүндэг даргад амжилт хүсье. Тусгай хяналтын дэд хорооны даргаар сонгогдлоо. Тусгай хяналтын дэд хороо маань төрийн нууц болоод мөн тагнуул болон гүйцэтгэх ажлын талаарх хууль тогтоомжийн биелэлт, мөн улсын хил хамгаалалт болон төрийн тусгай хамгаалалтын асуудлуудыг эрхэлдэг ийм чухал хариуцлагатай дэд хороо байгаа. Тэгээд дэд хорооны даргаар хариуцлагатай, ажил хэрэгчээр нэр төртэйгөөр ажиллана гэдэгт итгэлтэй байна. Тэгээд ажилд нь өндөр их амжилтыг хүсье Лүндэг даргад. Дэд хорооны дарга сонгох асуудлыг хэлэлцэж дууслаа.

12.56 цаг

Хоёр.Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн явцын талаар

Дараагийн асуудалдаа орцгооё. 2 дугаар асуудал. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн явцын талаарх мэдээллийг та бүхэнд танилцуулъя. Энэ талаарх мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Анар энэ холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр Байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн байгаа. Анар гишүүний микрофоныг өгье.

Ч.Анар: Эрхэм байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Кибер аюулгүй байдлын тухай хуулийн

хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй байгаа хүндрэл бэрхшээл болон нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох чиг үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахалж, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар, Улсын Их Хурлын гишүүн Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Батсүмбэрэл, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбүрэн нар ажиллалаа.

Кибер аюулгүй байдлын тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдаж, 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Тус хууль нь Кибер аюулгүй байдлын үндэсний тогтолцооны суурийг тавьсан боловч технологийн хөгжил, халдлагын төрөл, үндэсний мэдээллийн дэд бүтцийн хамаарал эрс өөрчлөгдсөн өнөөгийн нөхцөлд хуулийн хэрэгжилтийн бодит чадавх, шинэчлэлтийн хэрэгцээг эргэн харах шаардлага бий болсон байна. Ажлын хэсэг салбарын оролцогч байгууллага, хэрэгжүүлэгч байгууллага, мэргэжлийн холбоод, судлаач, эксперт, олон улсын байгууллагуудыг хамруулан ажиллав.

Тухайлбал, ажлын хэсгийн дэргэд дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсэг байгуулж, байгууллагуудын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хүндрэл бэрхшээл, хуулийн хэрэгжилтийн саад болон хуульд оруулах тодорхой саналын талаар 2 үе шаттайгаар бичгээр санал авсан. Америкийн нэгдсэн улсын Кибер аюулгүй байдлын Arogee компанийн төлөөлөл, Япон улсын Жайкагийн хэрэгжүүлж буй төслийн удирдлагууд, салбарын дотоодын болон олон улсын экспертүүдтэй нийт 9 удаагийн тусгайлан болон хамтарсан уулзалтыг хийсэн болно. 2026 оны 1 дүгээр сард Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас зохион байгуулсан салбарын хэлэлцүүлгийн үеэр хуулийн төсөлд оруулах санал, дүгнэлтийг авч, Ажлын хэсгийн судалгаанд нэгтгэсэн.

2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраас зохион байгуулсан GOVSEC арга хэмжээний үеэр төрийн онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага болон төрийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй байгууллагуудын хуулийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээлийн талаар нэмэлт санал асуулга авсан. Ажлын албанаас Эстони, Казахстан, Узбекистан, Япон, Сингапур, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг улсын кибер аюулгүй байдлын бодлого, эрх зүйн орчин, хяналтын зохицуулалтын тогтолцоог хамруулсан олон улсын харьцуулсан судалгаа хийж боловсруулсан болно.

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний хүрээнд 11 төрийн байгууллагад албан бичиг хүргүүлж, 10 байгууллагаас санал авч, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага, зөвшөөрөлтэй этгээд, төрийн өмчийн хуулийн этгээд, банк, мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэгч салбарын мэргэжилтэн иргэдээс нийт 7 төрлийн асуумжаар 25 хариулт цуглуулсан судалгаа хийв. 2026 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр ажлын хэсгийн хуралдаанаар олон улсын чиг хандлагад нийцүүлэн кибер аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүний хэсэг болгон авч үзэж, хуулийг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн шинэчилсэн найруулгын түвшинд боловсруулах шаардлагатай гэсэн байр сууринд ажлын хэсэг нэгдсэн болно.

Хуулийн хэрэгжилтийн талаарх ерөнхий үнэлгээг та бүхэнд танилцуулъя. Одоогийн хууль нь онц чухал мэдээллийн дэд бүтэц, эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төвүүдийн тогтолцоог нэг хуульд төвлөрүүлсэн ач холбогдолтой. Гэвч хэрэгжилтийн явцад

хууль нь бодит өндөр ачаалалтай, олон улс, олон байгууллага оролцсон, мэдээллийн урсгал төвүүд хоорондоо шилжих шаардлагатай нөхцөл бүрэн ажиллах хэмжээнд нарийвчлагдаагүй нь ажиглагдав.

Хуулийн хэрэгжилтэд дараах асуудлууд давтагдан гарч байна. 1 дүгээрт, Кибер аюулгүй байдлын зөвлөл, түүний алба, Цахим харилцаа холбоо, хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Үндэстний Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх Үндэстний төв, Нийтийн төв, Цагдаа, тагнуул болон бусад байгууллагууд стратегийн зохицуулалтын техникийн, хууль сахиулах чиг үүргийн зааг бүрэн тодорхой биш байна. Иймээс ноцтой халдлагын үед хэн нэгдсэн удирдлагаар хангаж, мэдээлэл аль сувгаар орж ирэх, аль шатанд шилжих, кейсийг хэрхэн хаах, хаасан, хэзээ хаагдсан гэж үзэх, буцах тайлагналд хийх процесс огт байхгүй байгаа нь тогтоогджээ.

2 дугаарт, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын ангилал эрсдэлд суурилсан, уян хатан хэлбэрээр бүрэн төлөвшөөгүй байна. ЗГ-ын 2022 оны 207 дугаар тогтоолоор баталсан жагсаалтад нийт 216 байгууллага үүнээс 134 төрийн, 82 хувийн хэвшил багтсан. Гэвч тухайн байгууллагуудын үйлчилгээ тасалдвал нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, хэрэглэгчийн тоо, өгөгдлийн хэмжээ, орлуулах үйлчилгээний боломж, хил дамнасан эрсдэл зэрэг шалгууруудыг илүү тодорхой болгох шаардлагатай байна. Ангиллын тодорхойгүй байдал нь зөвхөн жагсаалтын бус, Үндэстний төв, Нийтийн төвийн ачаалал, төсөв, хүний нөөц, арга хэмжээний чадавхад шууд нөлөөлж байна.

3 дугаарт, кибер аюулгүй, кибер халдлага зөрчлийг нэн даруй мэдэгдэх гэсэн ерөнхий зохицуулалт практикт хангалтгүй байна. Аль этгээд, ямар зөрчил, халдлага, хэдэн цагийн дотор, ямар маягтаар, ямар төвд мэдэгдэх, анхны мэдэгдэл, дэлгэрэнгүй тайлан, эцсийн тайлан, хэрэглэгчдэд мэдэгдэх үүрэг, нотлох баримт, хадгалах, сэргээх, сургамж авч сайжруулах дарааллыг хуулийн түвшинд тодорхой болгох шаардлагатай байна.

4 дүгээрт, аудит эрсдэлийн үнэлгээ, зөвшөөрлийн тогтолцоо эрх зүйн хувьд бүрдсэн боловч бодит хэрэгжих чадвар сул байна. Байгууллагууд ойлголт харилцан адилгүй, удирдлагын түвшний оролцоо хангалтгүй, тайлангийн чанарын шалгуур, сайжруулалтын төлөвлөгөө, биелэлтийн хяналт, аудитын чадавх, мэргэшсэн хүний нөөцийн бэлтгэл хангалтгүй байгаа нь хуулийн хэрэгжилтийг хэлбэр төдий болгож байна.

5 дугаарт, хүний эрх, хувийн мэдээлэл, бизнесийн нууц, халдлагатай холбоотой өгөгдлийг боловсруулах, хадгалах, дамжуулах харилцааг илүү нарийвчлах шаардлагатай. Кибер аюулгүй байдлын арга хэмжээ нь логик мэдээлэл, трафикийн өгөгдөл, төхөөрөмжийн дүрс хуулбар, зөрчлийн дараах тайлан зэрэг эмзэг мэдээлэлтэй шууд холбогддог тул хууль ёсны үндэслэл, зорилгоор хязгаарлах шаардлагатай хамгийн бага өгөгдөл авах, хадгалах хугацаа, устгах журам, маргах эрх, хөндлөнгийн хяналтын баталгаа зайлшгүй хэрэгтэй байна.

6 дугаарт, санхүүжилт, хүний нөөц, сургалт, мэргэшүүлэлтийн тогтвортой тогтолцоо хангалтгүй байна. Байгууллагад кибер аюулгүй байдлын тусгай төсөв, мэргэшсэн ажилтан, олон улсын сертификат, тогтмол сургалт, төр, хувийн хэвшлийн хамтарсан бэлтгэл дутмаг хэвээр байсаар байвал хуульд заасан үүрэг бодит хамгаалалт болж хэрэгжих боломж хязгаарлагдана. Дээрх нөхцөл байдалд

тулгуурлан Кибер аюулгүй байдлын тухай хуулийг хэсэгчилсэн нэмэлт, өөрчлөлтөөр бус, эрсдэлд суурилсан, хэрэгжилт нь хэмжигдэхүйц, кибер аюулгүй байдлыг гэхээсээ илүү кибер сөрөн тэсвэрлэх чадварт чиглэсэн шинэчилсэн найруулгын түвшинд боловсруулах нь зүйтэй гэж Ажлын хэсэг үзэв.

Ажлын хэсгийн дүгнэлтийг та бүхэнд эцэслэн танилцуулъя. Кибер аюулгүй байдлын одоогийн хууль нь үндэсний эрх зүйн суурийг тавьсан боловч өнөөгийн кибер аюулгүй байдлын хурд, цар хүрээ, технологийн өөрчлөлт, онц чухал үйлчилгээний хамаарал, мэдээллийн орчны эрсдэлтэй бүрэн нийцэхгүй болсон байна. Хуулийн хэрэгжилтэд байгууллага хоорондын уялдаа, чиг үүргийн зааг, мэдээллийн урсгал, буцах тайлагнал, зөрчилт арга хэмжээнд арга хэмжээ авах процесс, шаталсан процесс, аудит, эрсдэлийн үнэлгээний бодит хэрэгжилт, хариуцлага, санхүүжилт, хүний нөөцийн асуудал тогтолцооны шинжтэйгээр илэрч байна.

Кибер аюулгүй байдлыг зөвхөн халдлагаас хамгаалах бус, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах, тасралтгүй ажиллагааг хадгалах, сэргээн босгох, сургамж авч сайжруулах, бүх мөчлөгийг хамарсан кибер сөрөн тэсвэрлэх чадварын тогтолцоо болгон шинэчлэх шаардлагатай байна. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах, үндэсний мэдээллийн дэд бүтцийн эмзэг байдлыг бууруулах, кибер орчин дахь гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлийг тодорхойлсон тул энэхүү хуулийн шинэчлэл нь уг бодлогын баримт бичгийн хүрээ, хэрэгжилтийг хангах, эрх зүйн шинэ шат болох ёстой юм. Иймд Кибер аюулгүй байдлын тухай хуулийг шинэчилсэн найруулгын түвшинд боловсруулах нь зүйтэй гэж үзэж хуулийн төслийг Их Хурлын гишүүд санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх санал, дүгнэлтийг Байнгын хороонд танилцуулж байна. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн ахлагч Анар даргад баярлалаа. Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбоотойгоор асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Наранбаяр гишүүнээр тасалъя. Наранбаяр гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ танилцуулгыг нэлээн анхааралтай ажиглаж харлаа. Тэгэхээр энэ дээр яригдах зүйл нь когнитив дайн (Cognitive Warfare), кибер аюулгүй байдлын хүрээнд өнөөдөр яг физик маягаар дайрахгүй ч гэсэн буу зэвсэг агсаад, цэрэг оруулаад ийм биш, сонгуульд нөлөөлөх, худал мэдээллийг тараах. Худал мэдээлэл бол 6 дахин хурдтай илүү өргөн хүрээнд тардаг гэсэн ийм судалгааны үр дүн байдаг юм байна. Манайхан нөгөө ярьдаг шүү дээ. Үнэн дөнгөж босож байхад, худал аль хэдийн дэлхийг тойрчихсон байдаг гээд. Тэгэхээр ийм нөхцөл байдал дунд манай дээр ер нь энэ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, бусад холбогдох хуулиуд дээр, ялангуяа хиймэл оюун үүссэнээс хойших Бүтээмэл Оюун ч гэж яриад байгаа, үүссэнээс хойших энэ цаг үед яах вэ энэ хууль, эрх зүйн орчноо өөрчлөх шаардлага гараад байгааг ойлгож байна.

Гэхдээ жишээлбэл сонгуулийн үр дүнд ингээд нөлөөлчихсөн байвал яах юм бэ? Сая Унгарын сонгуулийг ажиглахад энэ бүүр гаарчихсан байна лээ шүү дээ. Бүүр ингээд, яах вэ ажиглана гэдэг нь зүгээр мэдээг нь л уншаад явахад. Тэгэхээр энэ дээр ер нь хаах ямар боломж байдаг юм бэ? Сөрөн тэсвэрлэх чадвар гэдэг нь

тэр урьдчилан сэргийлэх, хамгаалах гэдгээсээ илүү юугаараа ялгаатай юм бэ? Оруулж ирээд, орж ирсэн хойно нь бид ингээд тэсээд гардаг. Энэ бол худал мэдээлэл байна, энэ нь бол ийм байна гэдгийг хүмүүсийн ухамсарт суулгаж өгнө гэсэн үг юм уу, юу юм бол энэ талаар тодруулах гэсэн юм? Ер нь манайх Орос, Хятад гээд 2 том гүрний дунд байгаа, цаашаагаа гуравдагч хөршүүд байгаа. Ер нь зүгээр юуны хувьд тогтолцооны хувьд тийм яг ардчилал руу шилжиж чадаагүй, шилжээгүй, эсвэл хагас ардчилалтай ч юм уу ийм орнуудад ялангуяа энэ чиглэлийн тархи угаах худал мэдээлэл тараах ийм зохион байгуулалттай энийг хийх нь илүү хүчтэй ажиглагдаад байгаа.

Иргэд нь ч гэсэн яг энэ талаар хамгаалалт муутай, яагаад гэвэл тэр дунд нь дасаагүй, зохицоогүй, мэддэггүй байсан. Тэгэхээр энэ сөрөн тэсвэрлэх гэдэг дээрээ ямар, ямар чанаруудыг оруулж байгаа юм бэ гэж асуух гэсэн юм?

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Ажлын хэсгийн ахлагч Анар гишүүн асуултад хариулъя.

Ч.Анар: Энд нөгөө Кибер аюулгүй байдал гэдэг маань 1 дүгээрт нөгөө мэдээллийн аюулгүй байдлыг хангах гэж байгаа. Тэгэхээр энэ нөгөө худалч, худал хуурмаг мэдээлэл, санаатай болон санамсаргүй тараасан хуурмаг мэдээлэл бол кибер аюулгүй байдалтай хамааралгүй гэсэн үг. Энэ дээр нөгөө олон нийт ингээд ялгаж салгаж ойлгохгүй байгаа. Жишээ нь хуурамч контент зэрэг нь кибер аюулгүй байдлын асуудал биш. Гэхдээ та түрүүн маш зөв дурдаж байна. Когнитив дайн гэдэг дэлхий даяар бодитой болчихсон. Тэгэхээр когнитив дайн гэдэг маань үндэстнээр нь нэг бүрчлэн тухайн хүнд үзэл бодлыг нь өөрчлөх хэмжээний нөлөөллийн үйл ажиллагааг явуулж байгаа. Тэгэхээр тэр нөлөөллийн үйл ажиллагаанд тухайн хүний үзэл бодлыг өөрчлөх нөлөөллийн үйл ажиллагаа буюу мэдээллийн шинж чанартай хуурамч мэдээллээр үзэл бодлыг нь өөрчлөх үйл ажиллагааг ямар мэдээлэл дээр суурилж байна вэ гэхээрээ иргэний болон төрийн нууцад байгаа мэдээллийг олж аваад, илрүүлээд, тэрийгээ хиймэл оюун ухаанаар боловсруулаад, түүнийг ашиглаж худал мэдээлэл байдал боловсруулж, ард иргэд болон олон нийтэд нөлөөлж байгаа үйл ажиллагаа юм. Тэгэхээр бид тэрэнд худал мэдээлэл тараах түлшийг нь л бид хамгаалах гэж байна гэсэн үг хамгийн гол юм нь.

2 дугаарт өнөөдөр дэлхий даяараа бид хүн төрөлхтний амьдрал үндсэндээ кибер ертөнцөд амьдраад эхэллээ. Бид ухаалаг утас, ухаалаг машин, ухаалаг камерын систем, замын хөдөлгөөн бүх юм ухаалаг систем рүү шилжиж байгаа. Тэгэхээр үүн дээрээ суурилоод энэ асуудал маань зөвхөн иргэн болон тухайн байгууллагын хувийн мэдээлэл, байгууллагын нууцыг хамгаалах биш, өөрөө үндэсний аюулгүй байдлын асуудал болж байгаа юм. Энэ дээр сонгодог жишээ 2017 оны Америкийн сонгуульд нөлөөлсөн асуудлыг яриад байдаг. Тэрнээс хойш 8 жил өнгөрсөн, хиймэл оюун ухаан энэ хугацаанд үсрэнгүй хөгжсөн байгаа. Тэгэхээр бид яагаад энэ кибер аюулгүй байдал маань үндэсний хэмжээний аюулгүй байдал юм бэ гэхээрээ бидний өнөөдөр хэрэглэж байгаа ус, цахилгаан, мэдээлэл, эрүүл мэндийн мэдээлэл, худалдан авалтын мэдээлэл бүх юм энд хамгаалагдаж байдаг. Хэрвээ энийг алдвал бидний усан хангамж доголдох асуудал үүсэж болно.

2023 онд Калифорни мужид, Калифорни мужийг хордуулах үйл ажиллагаа кибер халдлагаар явагдсан. Сонгуулийн үйл ажиллагаанд нөлөөлж байна. Ялангуяа энэ хиймэл оюун ухаан хөгжиж байгаатай холбогдолтойгоор сонгуулийн үйл ажиллагаанд нөлөөлөх, 2010, 2017 оны Кембридж аналитикаас илүү ноцтой хэлбэр

лүүгээ шилжиж байгаа юм. Тийм учраас энэ нь өөрөө кибер аюулгүй байдал гэдэг маань зүгээр хамгаалах биш, илүү нэг ганц яамны асуудал биш, үндэсний аюулгүй байдлын асуудал болж байгаа юм гэдэг шинэчлэлийг энэ эрх зүйн хүрээнд шинэчлэх шаардлагатай байна.

Сөрөн тэсвэрлэх гэдэг маань ямар ялгаатай юм бэ гэхээрээ урьд нь кибер аюулгүй байдал гэдэг маань Цагаан хэрэм, энгийнээр хэлбэл Цагаан хэрэм бариад л хаачихдаг байсан халдлагыг. Одоо Цагаан хэрэм бариад хаах боломжгүй болсон дэлхий нийтээрээ. Улс орнууд хоорондоо кибер дайныг хийхдээ нууцаар хийдэг байсан бол орчин үеийн, одоогийн геополитикийн нөхцөл байдлаас улс хоорондын кибер дайн шууд болсон. Өөрөөр хэлбэл ямар нэгэн байдлаар нууцаар болон халдахгүйгээр шууд дайрдаг болчихсон байгаа. Тухайн улсын дэд бүтэц, олон нийтийн сэтгэл зүй рүү шууд халдлага үйлддэг болсон байгаа. Тэгэхээр энэ тохиолдолд яах вэ гэхээрээ бид халдагч этгээдийн гарал үүслийг нь мэдэж байгаа тохиолдолд зүгээр хаагаад зогсох биш, сөрөг арга хэмжээ авах олон улсын жишиг хандлага тийм болж байгаа юм. Тэгэхээрээ тэр чиг хандлагыг эрх зүйн хувьд нээж өгөхгүй бол бид халдаад байвал зардал хэмжээний хувьд ч, тэр эдийн засгийн хувьд ч тэр дийлэхгүй нөхцөл байдал үүсэж байгаа гэсэн үг.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Бум-Очир гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Бум-Очир: Өдрийн мэнд хүргэе. 1 хуулийн төсөл өргөн бариад хэлэлцүүлэх шатад явж байна. Ямар хуулийн төсөл вэ гэхээр Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах. Анар гишүүн маань надтай хамт энэ хууль дээр, хуулийн төсөл дээр ажилласан байгаа. Гэхдээ энэ дээр бусад гишүүдэд болоод олон нийтэд тодруулах зорилгоор кибер аюулгүй байдлын талаас нь асуулт асуумаар байна. Одоогийн энэ бидний өргөн барьсан хуулийн төсөл дээр орж байгаа нэмэлт, өөрчлөлтөөр өөрийнхөө бүртгэлтэй хаягаа шилжүүлэхгүйгээр байгаа газраасаа хамгийн ойрхон байгаа санал хураах байранд очоод сонгуулиа өгөх боломжтой болж байгаа. Ингэхээр тодорхой хэмжээгээр цахим үйл ажиллагаа энэ дээр татагдан орж байгаа. Энэ хэр аюулгүй вэ гэдгийг та нэг хэлж өгөөч?

Өөрөөр хэлбэл сонгогч би Бум-Очир байлаа гэхэд Улаанбаатарт бүртгэлтэй. Тухайн үед орон нутагт Өмнөговьд ч юм уу ажилтай явж таарлаа гэхэд тэр хамгийн ойрхон байгаа санал хураах байранд очоод саналаа өгчихнө гэсэн үг. Иргэний бүртгэлийн газартай бид холбогдож ажиллаж байгаа. Ер нь боломжтой гэж ойлгосон. Тэгэхээр 1-д энэ хэр боломжтой юм бэ? 2-т аюулгүй байдал талаасаа энэ ямар байх вэ гэдгийг та хариулж өгнө үү?

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн ахлагч Анар гишүүн асуултад хариулъя.

Ч.Анар: Тэгэхээр энийг хариуцаж байгаа чиг үүргийн байгууллага нь Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх Үндэсний төв байгаа. Тэгэхээр яг энэ процессын хувьд үндсэн чиг үүргээ Тагнуулын ерөнхий газар болон Сонгуулийн ерөнхий хороотой хамтраад өнөөдөр технологийн хувьд хангалттай найдвартай түвшинд хамгаалж ажиллаж байгаа. Тэр утгаараа таны асуултад би процессыг нь сайн мэдэхгүй ч гэсэн боломжтой гэж үзэж байгаа юм.

Өнөөдөр энэ эрх зүйн шинэчлэлийн хүрээнд юу өөрчлөх гээд байгаа юм бэ гэхээрээ 1 дүгээрт бид өөрснөө кибер аюулгүй байдал гэдэг ойлголтоо нийтээрээ мэдээллийн технологийн нэг хэсэг гэж ойлгоод байгаа нь маш том алдаа байгаа юм.

Тэгэхээр энэ дээр Сангийн яамны төсвийн бүтцэд Инновац, цахим бодлогын байнгын хороо 2024 онд өөрчлөлт оруулсан. 2 дугаарт болохоороо сонгуулийг дэлхий даяар цахим И Монгол аппликэйшн сайн хөгжсөн, дэлхий даяар явуулахад технологийн бүрэн боломжтой ч гэсэн, төсөв эдийн засгийн хүндрэлтэй байгаад байгаа. Тийм учраас нөгөө талаасаа энэ нь өөрөө технологийн хувьд бид болзошгүй эрсдэлээс эрсдэлтэй байна. Ялангуяа хангалттай хэмжээний кибер аюулгүй байдалд төсөв Монгол улсад тавигддаггүй.

Онц чухал мэдээллийн дэд бүтэц бүхий байгууллагууд, төрийн мэдээллийн нууцыг хамгаалж байгаа байгууллагууд маань аудитаа ч хийхгүй, тэрийг торгуулах замаар шалгуур үзүүлэлт хангахгүйгээр ингэж явж байгаа тохиолдолд бидэнд тодорхой хэмжээний эрсдэл үүсэж магадгүй гэсэн болгоомжлол Тагнуулын ерөнхий газраас гаргаж өгч байгаа юм. Хамгийн том эрсдэл нь ерөөсөө бид нөгөө иргэд, сонгогчдын итгэлцлийн асуудал сул байгаа тул энэ бол илүү технологи аюулгүй байдлын асуудал гэхээсээ илүү та бидний өргөсөн хууль дээр улс төрийн итгэлцэл сул байгаа учраас эхлээд суурийг нь тавиад, эрх зүйн хувьд сууриудыг нь бэлдье гэсэн байр суурьтай байгаа. Технологийн хувьд төсөв, боловсон хүчин нь байхад боломжгүй зүйл байхгүй. Өнөөгийн нөхцөл байдалд ч гэсэн аюулгүй байдлаа хангах бүрэн бололцоотой гэж харж байгаа.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Манай Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах Анар гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг маань 2025 оны 7 сард энэ ажлын хэсэг маань байгуулагдсан. Ингээд бүтэн жил гаруй хугацаанд ажлын хэсэг маань үр дүнтэй ажиллаж, одоогийн хууль, эрх зүйн орчин дээр, хуулийн хэрэгжилтийн ерөнхий байдал дээр үнэлэлт дүгнэлт хийж, хүндэрч байгаа асуудал, хүндрэл бэрхшээлүүдийг ингээд нарийвчлан тодорхойлсон байгаад байгаа.

Өнөөгийн нөхцөл байдал дээр дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашдаа яг энэ засаглал институт талаасаа ч тэр, нөгөө талдаа манай энэ чиг үүрэг асуудал хариуцсан байгууллагуудын чиг үүрэг, зааг ялгаа, үүрэг хариуцлага энэ бүхий л асуудлууд дээр хууль, эрх зүйн орчин талаасаа үнэлэлт дүгнэлт өгч, одоогийн нөхцөл байдлууд дээр бодит дүн шинжилгээ хийгээд, ингээд өнөөдөр ингээд ажлын хэсэг санал, дүгнэлтээ Байнгын хороонд танилцуулж байна. Ямар ч бай ингээд ажлын хэсэг ахалсан гишүүд болоод ажлын хэсгийн гишүүд маань Кибер аюулгүй байдлын тухай хууль дээр өөрчлөлт оруулах, ерөнхийдөө шинэчилсэн найруулгын төслийг бол бэлэн болгосон гэж ойлгож байгаа. Ингээд тун удахгүй энэ хаврын чуулгандаа амжаад Улсын Их Хуралд өргөн барина гэж ингээд хүлээж байгаа.

Ямар ч бай би Анар, ажлын хэсгийн ахлагчаар ажилласан Анар гишүүндээ болоод мөн ажлын хэсгийн гишүүдээр ажилласан Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар, мөн Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Батсүмбэрэл, Эрдэнэболд, Эрдэнэбүрэн нарын гишүүддээ талархал илэрхийлж байна. Тэгэхээр кибер аюулгүй байдлын асуудал өнөөдөр үндсэндээ үндэсний аюулгүй байдлын маш чухал асуудлын нэг болж байна. Цаг үе өөрөө их хувьсан өөрчлөгдөж байна. Орчин үеийн чиг хандлагад нийцүүлж, бид энэ хууль, эрх зүйн орчноо, тодорхой энэ засаглал, бүтэц зохион байгуулалтаа ч гэсэн өөрчлөх зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй Байнгын хороо бол үндсэндээ танилцаж дууслаа. Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцсанаар энэ ажлын хэсгийн үйл

ажиллагааг дуусгавар болгох нь зүйтэй гэсэн ийм саналтай байгаа. Ингээд мэдээллийг сонсож дууслаа. Нийт ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан гишүүддээ болоод Анар даргад чин сэтгэлийн талархлыг Байнгын хорооныхоо гишүүдийн өмнөөс дэвшүүлж байна. Баярлалаа та бүхэнд.

13.17 цаг

Хэлэлцэх асуудал хэлэлцэж дууслаа. Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх 2 асуудал маань дууссан байна. Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА